



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар №03

Ховд

Хурдан морины уралдааны талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаалаар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйл, хурдан морины уралдаанч хүүхдийн эрх хамгааллын асуудлыг олон нийт, эцэг эх, асран хамгаалагч, уяачдад сурталчлан таниулж ажиллахыг сумдын Засаг дарга, аймаг, сумын Морин спорт уяачдын холбооны тэргүүн нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Г.Цоодол) Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Түнжээ) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/67 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001-0175 Заг А/03 Кн